

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “17 дугаар сургууль”, “28 дугаар цэцэрлэг”, “Унага цэцэрлэг” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

“Хөрөнгө оруулалтын ажил- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн захиргааны байр барих ажил”, “Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар”, “27 дугаар цэцэрлэг”, “Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв”-ийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

2025.10.02-ны өдөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн засаг даргын А/785 дугаар захирамжийн дагуу 30ш бургас модыг "Тарлан толгойн энгэр"-т тариалаа.



2. Сургалт, зөвлөгөөн

- 2025.10.02-ны өдөр “Залуучуудын сарын аян”-ы хүрээнд Н.Алтанцоож багшаас “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтад бүх албан хаагчид хамрагдлаа.



- Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын 5.4 дэх заалтын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийг орон даяар нэвтрүүлэх сургалтад байгууллагын Нягтлан бодогч 2025.10.06-2025.10.07-ны өдрүүдүүдэд хамрагдлаа.



- 2025.10.08-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэсээс зохион байгуулсан “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал” сэдэвт сургалтад Газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар хамрагдлаа.
- 2025.10.09-ны өдөр “Төрийн албаны зөвлөл”-өөс зохион байгуулсан “Хяналт, шалгалтын хүрээнд илэрч байгаа зөрчил, дутагдал, эрсдэл, анхаарах асуудал” сэдэвт цахим сургалтад байгууллагын албан хаагчид хамрагдлаа.
- 2025.10.16-ны өдөр Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” цахим сургалт, мэдээллийн цагаар “Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл”-д байгууллагын Ахлах мэргэжилтэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн хамрагдлаа.



“7:4:10” ЦАХИМ СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЦАГ

Төрийн албаны Зөвлөлөөс тогтмол зохион байгуулдаг “7:4:10” цахим сургалт, мэдээллийн цаг 2025.10.16-ны өдрийн 10:00 цагт болно.

Энэ удаагийн мэдээллийн цагаар “Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл” хийнэ.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн бүх шатны төрийн байгууллагуудын удирдлага, төрийн албан хаагчид оролцохыг уриалж байна.

Огноо: 2025.10.16-ны өдрийн 10:00 цагт

Хаана: Цахимаар (вебинар)



ZOOM Meeting ID: 896 7830 0272

Passcode: 123456

Topic: Төрийн албаны зөвлөл 7-4-10 хөтөлбөр

Join from PC, Mac, iPad, or Android

<https://us06web.zoom.us/j/89678300272...>



- 2025.10.23-ны өдөр аймгийн ЗДТГазрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн хөтөч Г.Ганчимэг "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Авлигын эсрэг хууль" зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа.



- 2025.10.23-ны өдөр Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” цахим сургалт, мэдээллийн цагаар Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцгээ “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ”, Үндэсний Статистикийн Хорооны дарга Б.Батдаваа “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын талаар” зэрэг сургалт, мэдээлэлд байгууллагын албан хаагчид хамрагдлаа.

Монгол Улсын Төрийн албаны Зөвлөл
52m · 🌐

“7:4:10” ЦАХИМ СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЦАГ

Төрийн албаны Зөвлөлийн ээлжит “7:4:10” сургалт, мэдээллийн цагаар “Хүний эрхийн боловсролын талаар мэдээлэл” хийв.

Энэ удаагийн сургалт, мэдээллийн цагт Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцгээ “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ” сэдвээр, Үндэсний Статистикийн Хорооны дарга Б.Батдаваа “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын талаар” мэдээллүүдийг хүргэлээ.

ДЭЛГЭРЭНГҮЙГ ДООРХ БИЧЛЭГЭЭС ҮЗЭЭРЭЙ.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР